

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАРИЛЦААНЫ ДЭЭД СУРГУУЛЬ 2016 ОНД ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ

Оюутан элсүүлэх хөтөлбөр (мэргэжил)

- 1. Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал /өдөр, эчнээ/**
- 2. Эдийн засаг (хөдөлмөрийн эдийн засаг, бизнесийн эдийн засаг /өдөр, орой/)**
- 3. Менежмент (хүний нөөцийн менежмент /өдөр, эчнээ/, санхүүгийн менежмент)**
- 4. Нягтлан бодох бүртгэл (нягтлан бодох бүртгэл)**
- 5. Нийгмийн ажил (нийгмийн халамж, хангамж)**
- 6. Хөдөлмөрийн эдийн засаг /магистр/**

Нэг.Элсэлтийн комисс

1.1 Хөдөлмөр, нийгмийн харилцааны дээд сургуульд оюутан элсүүлэх үйл ажиллагааг сургуулийн захирлын тушаалаар томилогдсон элсэлтийн комисс зохион байгуулна.

1.2 Элсэлтийг зохион байгуулахад холбогдох хууль, тогтоомж болон “Оюутан элсүүлэх журам” энэхүү журмыг баримтална.

Хоёр. Элсэгчдэд тавигдах шаардлага

2.1 Тус сургуульд элсэгч нь бүрэн дунд ба түүнээс дээш боловсрол эзэмшсэн байвал зохино.

2.2 Элсэгч нь Боловсролын үнэлгээний төвөөс зохион байгуулсан ерөнхий шалгалтанд заавал хамрагдаж нийт онооны 50 хувиас багагүй (400) оноог авсан байна.

2.3 Тус сургуульд элсэгч нь нийгмийн тухай мэдлэг, математик, монгол хэл, гадаад хэл, физик, хичээлийн ерөнхий шалгалтын аль нэгэнд тэнцсэн байна.

2. Хоёр дахь дээд боловсрол эзэмших хүсэлтээ гаргасан иргэдийн элсэлтийн шалгалтыг сургууль зохион байгуулна.

2.5 Ерөнхий шалгалтын дүнгийн тухай баримт бичигт олгосон өдрөөс хойш 2 жил 5 сарын хугацаанд хүчинтэй байна.

Гурав.Элсэгчдийн хүсэлтийг хүлээн авч бүртгэх

3.1 Элсэгчид нь тус сургуулийн элсэлтийн комисст дараахи материалыг бүрдүүлж өгнө. Үүнд:

- а) Өргөдөл
- б) Батламж (Ерөнхий шалгалтын дүн, оноо)
- в) Боловсролын гэрчилгээ, хувийн хэрэг
- г) Бакалаврын диплом
- д) Иргэний үнэмлэхийн хуулбар
- е) Цээж зураг-3%
- ё) Бүртгэлийн хураамж-10000 төгрөг

3.2 Элсэгчдийг 07 дугаар сарын 01-ний өдрөөс 08 дугаар сарын 25-ны өдрийн хүртэл хугацаанд бүртгэнэ.

3.3 Элсэгчдэд эрхийн бичиг олгохдоо сургалтын төлбөрийн 50-иас доошгүй хувийг төлүүлсэн байна.

3.4 Эрхийн бичгийг зөвхөн тухайн элсэгчид зориулан бичиж олгоно.

3.5 Элсэгчид нь өөрийн болон эцэг, эхийн хаяг, холбоо барих утасны дугаарыг элсэгчдийн анкет дээр тодорхой бичнэ.

Дөрөв. Оюутан элсүүлэх шалгаруулалт

4.1 Элсэгчдийг ерөнхий шалгалтын онооны дарааллаар БСШУЯ-наас тогтоосон хяналтын тоонд багтаан элсүүлнэ.

4.2 Шалгуулагчийн ерөнхий шалгалтын оноо, бусад шаардлагыг хангасан эсэхийг харгалзан элсүүлнэ.

4.3 Элсэлтийн комисс оюутан элсүүлэх шалгаруулалтыг Улаанбаатар хотод өөрийн сургууль дээр, орон нутгаас оюутан элсүүлэх шалгаруулалтыг МИДСК-той хамтрах болон бие даан хэрэгжүүлнэ.

4.4 Элсэлттэй холбоотой маргаантай асуудлыг элсэлтийн комисс тухай бүр шийдвэрлэнэ.

Тав. Хөнгөлөлттэй нөхцлөөр элсүүлэх, сургах

№	Хөнгөлөлт үзүүлэх хувь, хэмжээ	Сургалтын төлбөрт эзлэх хувь /%/
1	МҮЭ-ийн Холбооны нэрэмжит тэтгэлэг (сар бүр)	10
2	ХНХДС-ийн Захирлын нэрэмжит тэтгэлэг (сар бүр)	5
3	Хөгжлийн бэрхшээлтэй оюутанд	10-50
4	Хагас болон бүтэн өнчин, нэн ядуу, ядуу өрхөд амьдардаг оюутанд	10-40
5	Сурлагын тогтвортой, өндөр амжилт үзүүлсэн оюутанд	20-50
6	Оюутны зөвлөлийн гишүүдэд	10
7	Урлаг, спортын өндөр амжилт гаргасан оюутанд	10-25
8	Үйлдвэрчний эвлэлийн байгууллагад ажиллахын зэрэгцээгээр суралцаж буй оюутанд	10-30
9	Ерөнхий шалгалтын оноо 500-с дээш оюутанд	5
10	Ерөнхий шалгалтын оноо 600-с дээш оюутанд	10
11	Ерөнхий шалгалтын оноо 700-с дээш оюутанд	15
12	Математик, нийгмийн тухай мэдлэг хичээлээр 2013-2014 онуудад аймаг, хот, улсын олимпиадад 1-3 байр эзэлсэн элсэгчийг шууд элсүүлнэ.	20
13	Төрийн сангийн буцалтгүй зээл, тусламж, төрийн албан хаагч	100

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАРИЛЦААНЫ ДЭЭД СУРГУУЛЬ